

ХАР ТӨМӨРЛӨГИЙН ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ЗОРИЛТОТ ХӨТӨЛБӨР

Нэг. Хөтөлбөр боловсруулах үндэслэл

Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалд “Монгол Улсын ойрын 15-25 жилийн хөгжлийн гол стратеги нь нийгмийн баримжаатай, байгаль орчиндоо зохицсон, оюуны болон технологийн шинэ суурьт тулгуурласан, экспортын чиглэл бүхий харьцангуй бие даасан эдийн засагтай үйлдвэржсэн орон болох явдал мөн” гэж;

Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогын 2 дугаар тэргүүлэх чиглэлийн хүрээнд “Экспортын баримжаатай, хувийн хэвшилд түшиглэсэн өндөр технологт уул уурхайн бүтээгдэхүүнийг гүн боловсруулах үйлдвэрлэлийг эрчимтэй хөгжүүлж, тогтвортой, мэдлэгт суурилсан эдийн засгийг бий болгох, стратегийн ач холбогдолтой ашигт малтмалын ордуудыг ашиглан хуримтлал бий болгож, эдийн засгийн эрчимтэй, өндөр өсөлтийг ханган, орчин үеийн боловсруулах салбарын үйлдвэрлэлийг хөгжүүлж эдийн засгийг олон талтай болгож, ашигт малтмалаас харьцангуй бага шалтгаалдаг орон болно” гэж;

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3 дугаар зүйлийн 3.2.2.1 дэх заалтад “Үндэсний хөрөнгө оруулагчдын эдийн засаг дахь хувь, оролцоог нэмэгдүүлэх, хамгаалах бодлого хэрэгжүүлж, бизнесээ өргөжүүлэх, олон улсын тавцанд өрсөлдөх чадвараа дээшлүүлэх, улмаар улс орны эдийн засгийн аюулгүй байдал, хөгжил дэвшилд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэх боломжийг бүрдүүлнэ” гэж;

Улсын Их Хурлын 2015 оны 62 дугаар тогтоол “Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого”-ын баримт бичгийн 4.2.3.6 –д “Хар төмөрлөгийн үйлдвэрийг дагалдах үйлдвэрийн хамт цогцоор нь байгуулах” гэж тус тус заасан нь “Хар төмөрлөгийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилтот хөтөлбөр”-ийг боловсруулах эрх зүйн үндэслэл болно.

Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлогын баримт бичигт эрдэс баялгийн боловсруулалтын түвшинг ахиулах, зах зээлд өрсөлдөхүйц бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг хөгжүүлэх; дэвшилтэт техник, технологийг нутагшуулах, шинжлэх ухаан, үйлдвэрлэлийн уялдааг хангах тогтолцоог бүрдүүлэх, инновацийг дэмжин хөгжүүлж бүтээмжийг өсгөх; ашигт малтмалын орд газар, дэд бүтцийг түшиглэн үйлдвэрийн стратегийн байршлыг тодорхойлж байгуулах; үйлдвэрүүдийн цогцолборыг байгуулж түүхий эд, нөөцийн ашиглалт, мөнгөний эргэлтийг хурдасгах; хүний нөөцийн цогц менежментийг нэвтрүүлэх, үйлдвэрүүдийн уялдааг хангах, кластерыг хөгжүүлэх зорилтуудыг тусгасан байдаг.

Хар төмөрлөгийн үйлдвэрлэл нь төмрийн хүдэр, ганг чанаржуулагч эрдсүүдийг боловсруулан аргалж, хорголож, шууд ангижруулсан төмөр, ширэм, ган, төмрийн төрөл бүрийн бэлдэц, феррохайлш (ферросиликон, ферромангаан, феррохром, ферромагнезиум, ферроникель, ферровольфрам, ферромolibден, ферротитан, феррованади, феррониоби, ферроаллюминиум, ферросериум, ферроборон, феррофосфор, ферроураниум, мангаантсиликон, ферросиликонмагнезиум), металлургийн кокс үйлдвэрлэх, галд тэсвэртэй материал, бентонит, цутгуурын хэвний элс, жонш, шохой, нийллэг хий, хүчилтөрөгчийн нийлүүлэлт, цахилгаан эрчим хүч, үйлдвэрлэлийн усны хангамж, тээвэр ложистик, бүтээгдэхүүний маркетинг, төрийн худалдан авалт, хүний нөөцийн менежмент, эрүүл ахуй, хөдөлмөр хамгаалал, байгаль орчин зэрэг цогц хүрээнд үйл ажиллагаа нь явагддаг тул улс орны нийгэм-эдийн засгийн шинэ бүтцийг бий болгон хөгжүүлэхэд онцгой байр суурийг эзлэх болно.

Хоёр. Зорилтот хөтөлбөрийн хамрах хүрээ, хэрэгжүүлэх хугацаа, баримтлах зарчим

2.1 Хамрах хүрээ

- 2.1.1 Түүхий эд, материалын үйлдвэрлэл (*нүүрсний хий, металлургийн кокс, шохой, галд тэсвэртэй материал, жонш, бентонит, цутгуурын элс гэх мэт*)
- 2.1.2 Төмрийн хүдрийн баяжуулалтын дараах боловсруулалт (*аргалж, хорголж,*)
- 2.1.3 Шууд ангижруулсан төмрийн үйлдвэрлэл
- 2.1.4 Ширмийн үйлдвэрлэл
- 2.1.5 Феррохайлшийн үйлдвэрлэл
- 2.1.6 Гангийн үйлдвэрлэл
- 2.1.7 Цутгуурын үйлдвэрлэл (*ган бөмбөлөг, барилгын металл хийц гэх мэт*)
- 2.1.8 Дэд бүтцийн салбар (*инженерийн шугам сүлжээ, эрчим хүч, усны хангамж*)
- 2.1.9 Бүтээгдэхүүний маркетинг (*дотоод худалдаа, экспорт, төрийн худалдан авалт*)
- 2.1.10 Хүний нөөцийн менежмент (*хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа*)
- 2.1.11 Байгаль орчин (*сөрөг нөлөөлөл багатай үйлдвэрлэл*)

2.2 Хэрэгжүүлэх хугацаа

Зорилтот хөтөлбөрийг 2016 -2030 онд хэрэгжүүлнэ. /“Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого”-ыг хэрэгжүүлэх хугацаатай ижил/

2.3 Баримтлах зарчим

- 2.3.1 тогтвортой хөгжлийн зарчимд нийцсэн, хүрээлэн буй орчинд ээлтэй үйлдвэрлэлийг дэмжих;
- 2.3.2 экспортын чиг баримжаатай, импортыг орлох эцсийн бүтээгдэхүүний үндэсний үйлдвэрлэлийг дэмжих;
- 2.3.3 дэвшилтэт техник, технологид суурилсан өрсөлдөх чадвар бүхий инновацийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих;
- 2.3.4 төр, шинжлэх ухаан, иргэний нийгэм, хувийн хэвшлийн түншлэлийн үр ашигтай хамтын ажиллагаанд тулгуурлах;
- 2.3.5 мэдээлэлийн ил тод байдал, оролцогч талуудын шударга өрсөлдөөнийг дэмжих зэрэг зарчмыг баримтлана.

Гурав. Хөтөлбөрийн зорилго, зорилт

3.1 Хөтөлбөрийн зорилго:

Эрдэс баялагийн нөөц, дэвшилтэт техник, технологи, монгол инженерүүдийн чадавхи дээр тулгуурлан төмөр, ган бэлдэц бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээг хангах, металлургийн кокс, феррохайлшийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэн экспортыг дэмжихэд оршино.

3.2 Хөтөлбөрийн зорилт

Зорилт 1. Төмрийн хүдэр, ганг чанаржуулагч эрдсүүд, галд тэсвэртэй материалуудын нөөцийг баталгаажуулан үндэсний үйлдвэрүүдийг стандартад нийцсэн түүхий эд, материалаар урт хугацаанд тогтвортой хангах;

Зорилт 2. Гангийн үйлдвэрүүдийг цогцолбор хэлбэрээр, түүхий эд, материал болон хайлшийн үйлдвэрүүдийг ашигт малтмалын ордыг түшиглэн барьж байгуулах;

Зорилт 3. Төмрийн бэлдэц, гангийн бүтээгдэхүүний өөрийн өртгийг бууруулж, чанарыг дээшлүүлэх замаар өрсөлдөх чадвар бүхий бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх;

Зорилт 4. Дэвшилтэт техник, технологид суурилсан металлургийн кокс, ган, хайлшийн үйлдвэрүүдийг төрийн санхүүжилтийн бодлогоор дэмжих;

Зорилт 5. Бүтээгдэхүүн, түүхий эдийн чанарын хяналт, стандартчлал, техникийн зохицуулалтыг үйлдвэрлэлд нэвтрүүлж, байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийг багасгах;

Зорилт 6. Үйлдвэрийн аюулгүй ажиллагааны байдлыг хангах. хүний нөөцийн эрэлтэд суурилсан боловсон хүчин бэлтгэх, тогтвор суурьшилтай ажиллах орчин, эрүүл ахуйн нөхцлийг сайжруулах;

Дөрөв. Хөтөлбөрийн зорилтын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ

4.1 Төмрийн хүдэр, ганг чанаржуулагч эрдсүүд, галд тэсвэртэй материалуудын нөөцийг баталгаажуулан үндэсний үйлдвэрүүдийг стандартад нийцсэн түүхий эд, материалаар урт хугацаанд тогтвортой хангах зорилтын хүрээнд:

- 4.1.1 төмрийн хүдэр, ганг чанаржуулагч эрдсүүдийн нөөцийг баталгаажуулах ажлыг 2016-2025 онуудад хийх;
- 4.1.2 ганг чанаржуулагч эрдсүүд, галд тэсвэртэй материалуудыг гангийн үйлдвэр, түүхий эд, материалын үйлдвэрүүдийн төлөвлөлттэй уялдуулан геологийн хайгуулын ажлыг улсын төсвийн хөрөнгөөр хийх асуудлыг судлан шийдвэрлэх;
- 4.1.3 нөөц нь тогтоогдсон төмрийн хүдрийн ордуудын хүдрийн баяжигдах шинж чанар, хорт хольцуудыг багасгах боломжийн судалгаануудыг хийх;
- 4.1.4 галд тэсвэртэй материалуудын нөөцийг тогтоож, боловсруулах үйлдвэрлэлд нийлүүлэх судалгааны ажлыг хийх;
- 4.1.5 шаардлагатай галд тэсвэртэй материалуудын төрөл, нөөц, байршил, ашиглалтын байдлын талаар мэдээллийн сан бүрдүүлж, боловсруулалтад тавигдах техникийн шаардлагыг тодорхойлох, хоёрдогч ашигт малтмалаас ялган авах техник, технологийг оновчлох, гадаад улсуудын туршлагыг судлах;
- 4.1.6 үйлдвэрлэлд нийлүүлэгдэх үндсэн түүхий эд болон нэмэлт материал шохой, доломит, бентонитын стандартуудыг боловсруулж, батлуулах;
- 4.1.7 стандартад нийцсэн түүхий эд, материалуудыг үндэсний үйлдвэрлэгчдэд бэлтгэн нийлүүлэх маркетингийн бодлогыг хэрэгжүүлэх;
- 4.1.8 түүхий эд, материалуудын нийлүүлэлтийг олон улсын худалдааны гэрээний шаардлагад нийцүүлэх;
- 4.1.9 2023 оноос ганг чанаржуулагч эрдсүүдийн хүдэр, баяжмалыг, 2025 оноос төмрийн хүдэр, баяжмалыг экспортод гаргахыг бүрмөсөн хориглох эрх зүйн орчинг бий болгох, үндэсний үйлдвэрлэлийг урт хугацаанд стандартад нийцсэн түүхий эд, материалаар тогтвортой хангах нөхцлийг бүрдүүлэх;

4.2 Гангийн үйлдвэрийг цогцолбор хэлбэрээр, түүхий эд, материал, хайлшийн үйлдвэрүүдийг ашигт малтмалын орд газрыг түшиглэн барьж байгуулах зорилтын хүрээнд:

№	Үйлдвэрүүдийн байршил, хүчин чадал, ашиглалтанд орох хугацаа	Бүтээгдэхүүний нэр, код
4.2.1	Орхон аймагт жилийн 100 мянган тонн ширэм үйлдвэрлэх хүчин чадалтай үйлдвэрийн төслийн хэрэгжилтийг 2018 онд багтаан дуусгах;	ширэм 7201.10-7201.50
4.2.2	Орхон аймагт Эрдэнэтийн УБҮ-ийн засвар механикийн цехийг жилийн 100 мянган тонн ган бөмбөлөг, тээрмийн хуяг, бусад эд анги үйлдвэрлэх уул уурхайн тоног төхөөрөмжийн үйлдвэр болгон өргөтгөн 2020 оны эцэст ашиглалтанд оруулах;	ган бөмбөлөг 7326.11, тээрмийн хуяг, эд анги 7325.99
4.2.3	Орхон аймагт жилийн нэг мянган тонн ферротитан үйлдвэрлэх хайлшийн үйлдвэрийг барьж, 2020 онд ашиглалтанд оруулах;	титант төмөр 7202.91 ферротитан 70% Ti
4.2.4	Дархан-Сэлэнгийн бүсэд жилийн 500 мянган тонн аргалж, хорголж үйлдвэрлэх үйлдвэрийг 2018 онд барьж байгуулах;	
4.2.5	Дархан-Сэлэнгийн бүсэд жилийн 500 мянган тонн шууд ангижруулсан төмөр, 350 мянган тонн ган үйлдвэрлэх хар төмөрлөгийн цогцолборыг дэд бүтцийн хамт 2020 онд багтаан барьж байгуулах;	шууд ангижруулсан төмөр 7203.10.00 чанаржуулаагүй ган 7206-7217
4.2.6	Дарханы төмөрлөгийн үйлдвэрийн хүчин чадлыг жилийн 100 мянган тонн ган туйван, U-хэлбэрт төмөр, I- хэлбэрт төмөр, H-хэлбэрт төмөр үйлдвэрлэх барилгын металл хийцийн үйлдвэрлэл, 50 мянган тонн рейс, зам төмөр шилжүүлэгч, чагтан холбоос, суурийн хавтан үйлдвэрлэх төмөр замын байгууламжийн үйлдвэрлэл болгон 2025 онд өргөтгөж дуусгах;	ган туйван 7228.20 U-хэлбэрт төмөр 7216.31 I-хэлбэрт төмөр 7216.32 H-хэлбэрт төмөр 7216.33 зам төмөр шилжүүлэгч 7302.10 чагтан холбоос 7302.30, суурийн хавтан 7302.40
4.2.7	Дарханы цемент-шохойн үйлдвэрийг 2016-2018 онд өргөтгөн шинэчилж, жилийн 50 мянган тонн силикокарбид, 50 мянган тонн доломит (шатаасан, хайлуулсан бадмар) үйлдвэрлэж, гангийн үйлдвэрүүдэд нийлүүлэх;	силикокарбид 2849.20.00 доломит 2518.20
4.2.8	Чех улсын техник, технологээр жилийн 300 мянган тонн хүчин чадалтай металлургийн коксын үйлдвэрийг Дархан хотод цементийн үйлдвэртэй хоршуулан барьж байгуулан 2018 оны эцэст бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн байх;	кокс 2704.00.10
4.2.9	Дарханы байшин үйлдвэрлэх үйлдвэрийг жилийн 50 мянган тонн ферросиликон үйлдвэрлэх хайлшийн үйлдвэр болгон 2018 онд багтаан өөрчлөх;	цахиурт төмөр 7202.21.00 силикомарганец 65% Mn
4.2.10	Улаанбаатар хотод жилийн 20 мянган кг композит материал үйлдвэрлэх үйлдвэрийг ШУТИС-ийн бааз болгон 2025 онд барьж байгуулах;	
4.2.11	Багануурт жилд 5000 кг нүүрсэн сойз, 10 000 кг нүүрсэн электродын үйлдвэрийг 2017 оны эцсээр ашиглалтанд оруулж, гангийн үйлдвэрт бүтээгдэхүүнээ нийлүүлнэ.	нүүрсэн сойз 8545.20-8545.90 нүүрсэн электрод 8545.11-8545.19
4.2.12	Багахангайд жилийн 50 мянган тонн шамот, динас, муллит, үйлдвэрлэх галд тэсвэртэй материалын үйлдвэрийг 2018 онд барьж ашиглалтанд оруулах;	шамот тоосго 2508.70 муллит 2808.60

4.2.13	Багахангайд жилийн 5000 тонн ферровольфрам үйлдвэрлэх хайлшийн үйлдвэрийг 2020 онд барьж байгуулан ашиглалтанд оруулах;	гянтболдот төмөр 7202.80 ферровольфрам 75% W
4.2.14	Багахангайд жилийн 5000 тонн ферромангаан үйлдвэрлэх хайлшийн үйлдвэрийг 2020 онд барьж ашиглалтанд оруулах;	мангаант төмөр 7202.11 ферромарганец 73-75% Mn
4.2.15	Архангай аймагт жилийн 5000 тонн ферромолембин үйлдвэрлэх хайлшийн үйлдвэрийг барьж, 2018 онд ашиглалтанд оруулах;	молибдент төмөр 7202.70 ферромолембин 65-70% Mo
4.2.16	Сүхбаатар аймагт 100 мянган тонн бентонит үйлдвэрлэх хүчин чадалтай үйлдвэрийг 2019 онд барьж, ашиглалтанд оруулах;	бентонит 2508.10
4.2.17	Сайншандад жилийн нэг сая тонн хүртэл металлургийн кокс үйлдвэрлэх кокс-химийн үйлдвэрийн төслийн барилгын ажлыг 2018 онд багтаан эхлүүлэх;	кокс 2704.00.10
4.2.18	Дорнод аймагт жилийн 10 мянган тонн цутгуурын хэвний элс боловсруулах үйлдвэрийг 2017 онд барьж байгуулах;	Элс 2505.90
4.2.19	Баруун бүсэд хар төмөрлөгийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх боломжийн талаархи судалгааг 2017-2018 онуудад хийж гүйцэтгэх;	
4.2.20	Ховд аймагт жилийн 10 мянган тонн ферромангаан үйлдвэрлэх хайлшийн үйлдвэрийг 2025 онд барьж байгуулах;	мангаант төмөр 7202.11 ферромарганец 73-75% Mn
4.2.21	Говь-Алтай аймагт жилийн 5 мянган тонн феррохром үйлдвэрлэх хайлшийн үйлдвэрийг 2025 онд барьж байгуулах;	хромт төмөр 7202.41 феррохром 65% Cr

4.3 Төмрийн бэлдэц, ган, хайлш бүтээгдэхүүний өөрийн өртгийг бууруулах, чанарыг дээшлүүлэх замаар өрсөлдөх чадвар бүхий бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд:

- 4.3.1 үйлдвэрлэлийн явцад гарах дагалдах бүтээгдэхүүнийг ашиглах техник технологийн шийдэл, бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээг тодорхойлох;
- 4.3.2 хар төмөрлөгийн цогцолбор нь өөрийн хэрэгцээний нүүрс, ус, уур, дулаан, цахилгаан эрчим хүчийг хэмнэх техник, технологийн шийдлийг дэмжих;
- 4.3.3 төмөр, ган бүтээгдэхүүний дотоодын эрэлт, хэрэглээг нэмэгдүүлэхийг дэмжих;
- 4.3.4 гангийн үйлдвэр, түүхий эд, материалын болон хайлшийн үйлдвэрүүдийг барьж, байгуулах, тогтвортой ажиллуулах үйл ажиллагааг гадаад улсад суугаа элчин сайдын яамд, төрийн бус байгуулагууд, орон нутгийн бүх шатны байгууллага, иргэдээс дэмжин ажиллах асуудлыг судалж, эрх зүйн орчинг бий болгох;
- 4.3.5 төмрийн бэлдэц, ган, хайлш бүтээгдэхүүний чанарыг дээшлүүлэх тал дээр өндөр хөгжилтэй улс орнуудаас техникийн туслалцаа, зөвлөх үйлчилгээг авч ашиглах;
- 4.3.6 төмрийн бэлдэц, гангийн бүтээгдэхүүний өөрийн өртгийг бууруулах тал дээр дэвшүүлсэн санал, санаачлагуудад бүх талын дэмжлэг үзүүлэх;

4.4 Дэвшилтэт техник, технологид суурилсан ган, хайлшийн үйлдвэрүүдийг төрийн санхүүжилтийн бодлогоор дэмжих зорилтын хүрээнд:

- 4.4.1 инноваци, өндөр технологи, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн гарган авах судалгаа, патент, оюуны өмчийн эрх, экспортод нийлүүлэгдэх ган, хайлш,

металлургийн коксын үйлдвэрлэлийн төслүүдийг “Үйлдвэржилтийг дэмжих сан”-гаас санхүүжүүлэх;

- 4.4.2 төмөрлөгийн үйлдвэрийг өргөтгөх болон шинээр барихтай холбогдсон төслийг урт хугацаатай, бага хүүтэй зээлээр санхүүжүүлэх асуудлыг судалж шийдвэрлэх;
- 4.4.3 улсын төсвийн хөрөнгө оруулалт, концессоор барих дэд бүтэц, иргэний болон үйлдвэрийн барилга, байгууламж, зам, барилгын суурьд шаардагдах төмөр, ган, хайлш түүгээр хийсэн хийцүүд, шаараг, галд тэсвэртэй материалуудыг дотоодоос худалдан авах талаар тендерийн нөхцөл, гэрээнд заавал тусгаж байх;
- 4.4.4 гадаад улс орнуудын экспортын агентлагаар дамжуулан олгодог техник, тоног төхөөрөмжийн зээлийн нөхцлийг хөнгөвчлөх асуудлыг судалж хэрэгжүүлэх;
- 4.4.5 төр, шинжлэх ухаан, боловсрол, бизнесийн байгууллагуудын хамтын ажиллагааг дэмжих, экспортод чиглэсэн хайлшийн үйлдвэрлэлийг бий болгох;
- 4.4.6 гангийн, түүхий эд, материал, хайлшийн үйлдвэрүүдийн зарим бүтээгдэхүүний дотоодын зах зээлийг хамгаалах арга хэмжээг ижил төрлийн бүтээгдэхүүний гаалийн тарифын ба тарифын бус зохицуулалтаар авч хэрэгжүүлэх;
- 4.4.7 гангийн үйлдвэр, түүхий эд, материал, хайлшийн үйлдвэрүүдэд ашиглагдах техник, тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл, урвалж материалыг гааль, нэмэгдсэн өртгийн татвараас үе шаттайгаар хөнгөлөх асуудлыг судлан шийдвэрлэх;
- 4.4.8 гангийн үйлдвэр, түүхий эд, материал, хайлшийн үйлдвэрүүдийг барьж байгуулах үе шатанд газрын төлбөрөөс чөлөөлөх асуудлыг судлан шийдвэрлэх;
- 4.4.9 гангийн үйлдвэр, түүхий эд, материал, хайлшийн үйлдвэрүүдэд ашиглах усны төлбөрийг бүтээгдэхүүнээ зах зээлд нийлүүлсэнээс хойш 2 жилийн дараа төлөх эрх зүйн орчныг бий болгох, хаягдал усыг эргүүлэн ашиглах технологи нэвтрүүлэхэд усны төлбөрөөс чөлөөлөх асуудлыг судлан шийдвэрлэх;

4.5 Бүтээгдэхүүн, түүхий эдийн чанарын хяналт, стандартчлал, техникийн зохицуулалтыг үйлдвэрлэлд нэвтрүүлж, байгаль орчинд нөлөөлөн сөрөг нөлөөллийг багасгах зорилтын хүрээнд:

- 4.5.1 гангийн үйлдвэр, түүхий эд, материал, хайлшийн үйлдвэр барих төслийн урьдчилсан техник-эдийн засгийн үндэслэлийг төслийн байгаль орчин-нийгмийн нөлөөллийн үнэлгээтэй хамт хийлгэх;
- 4.5.2 үйлдвэрийн төслийн ТЭЗҮ, инженерийн зураг төслийг аж үйлдвэрийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, “Металлурги инженеринг” мэргэжлийн холбоотой хамтарч хэлэлцэн дүгнэлт гаргах;
- 4.5.3 төмөрлөгийн салбарт АНУ-ын стандартуудыг манай орны нөхцөлд тохируулан нутагшуулах ажлыг зохион байгуулах, бүтээгдэхүүний чанарыг олон улсын стандартын түвшинд хүргэх;
- 4.5.4 бүтээгдэхүүн, түүхий эдийн чанарын хяналтанд автоматжуулсан лабораторийг ашиглахыг дэмжих;
- 4.5.5 төмөрлөг бүтээгдэхүүний шинжилгээний иж бүрэн лабораторийг 2018 онд ган, төмөр болон шаараганд зориулсан бүрэн автомат системтэй хамт байгуулах;
- 4.5.6 чанаржуулсан ширэм, энгийн, нүүрстөрөгчит, чанаржуулсан ган, хийцийн үндэсний марклал, тэмдэглэгээ, чанарын нэгдсэн аргачлалыг “Металлурги инженеринг” мэргэжлийн холбоо тодорхойлох, бүх үйлдвэрүүдэд нэвтрүүлэх арга хэмжээг авч ажиллах;
- 4.5.7 үйлдвэрийн техник, технологид хэрэглэгдэх химийн бодис, урвалж, катализатор, композит материалын нийлүүлэлт, хадгалалт, тээвэрлэлт, устгалт, хоргүйжүүлэлтийн техникийн зохицуулалт боловсруулж батлуулан мөрдүүлэх;
- 4.5.8 үйлдвэрлэлийн технологи, дэд бүтцэд ногоон эрчим хүч ашиглах, хаягдал усыг стандартын түвшинд хүртэл цэвэрлэж, дахин ашиглах технологи нэвтрүүлэх, хатуу хаягдлыг дахин боловсруулахыг дэмжих;
- 4.5.9 гангийн үйлдвэрлэлээс ялгаруулж буй хүлэмжийн хийн хэмжээг багасгах техник, технологийн шийдлийг нэвтрүүлэх;
- 4.5.10 гангийн үйлдвэрлэлээс ялгарах хийг хэмжиж тайлагнах, нотлох тогтолцоог шинээр бий болгох;

4.6 Үйлдвэрийн аюулгүй ажиллагааны байдлыг хангах, хүний нөөцийн эрэлтэд суурилсан боловсон хүчин бэлтгэх, тогтвор суурьшилтай ажиллах орчин, эрүүл ахуйн нөхцлийг сайжруулах зорилтын хүрээнд:

- 4.6.1 “хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай” хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, “төмөрлөгийн салбарын эрүүл ахуй, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрэм”-ийг шинээр боловсруулж мөрдөх;
- 4.6.2 төмөрлөгийн үйлдвэрийн эрүүл ахуй, технологийн аюулгүй ажиллагаа, хөдөлмөр хамгаалалын нөхцлийг судлах, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх, хэрэгжилтийг хангах;
- 4.6.3 инженер, техникийн ажилтан, мэргэжилтэй ажилчдыг дотооддоо бэлтгэх, чадавхжуулах тогтолцоог сайжруулах;
- 4.6.4 инженер, техникийн ажилтан, мэргэжилтэй ажилчдыг хөгжингүй орнуудад дадлагажуулах тогтолцоог бий болгох;
- 4.6.5 төмөрлөгийн салбарын мэргэжилтэй ажилтан сургах, ажил эрхлэлт, шилжилт хөдөлгөөний мэдээг багтаасан салбарын нэгдсэн мэдээллийн сан байгуулах
- 4.6.6 хүний нөөцийн менежментийг үйлдвэрүүдэд оновчтой хэрэгжүүлэх;
- 4.6.7 бүтээмжийг нэмэгдүүлэх замаар инженер, техникийн ажиллагсдын цалин, хөлсний орлогыг 2025 онд хөгжингүй орнуудын жишигт ойртуулах;
- 4.6.8 гангийн, түүхий эд, материал, хайлшийн үйлдвэрүүдэд ажиллагсдын ажилласан жилийн нэмэгдэл, мэргэжлийн зэрэг, дэв олгох, эрүүл мэнд, хариуцлагын болон тэтгэврийн арилжааны даатгалд даатгуулах асуудлыг судлан шийдвэрлэх;

Тав. Зорилтот хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, хянах

5.1 Хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагааны 3 жилийн нарийвчилсан төлөвлөгөөг “Аж үйлдвэрийн бодлогын зөвлөл” хэлэлцэж, аж үйлдвэрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

5.2 Хөтөлбөрийг аж үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага бусад яам, агентлаг, орон нутгийн захиргааны байгууллага, гадаад дотоодын хөрөнгө оруулагчид, “Металлурги инженеринг” мэргэжлийн холбоо, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, боловсрол, шинжлэх ухааны байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.

Зургаа. Зорилтот хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүжилт

6.1 Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний санхүүжилтийг дараах эх үүсвэрээс бүрдүүлнэ.

- 6.1.1 гадаад, дотоодын аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн хувийн хөрөнгө оруулалт;
- 6.1.2 улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө;
- 6.1.3 хөгжлийн банк, арилжааны банкны зээлийн хөрөнгө;
- 6.1.4 баялагийн сангийн хөрөнгө;
- 6.1.5 үйлдвэрлэлийг дэмжих сангийн хөрөнгө;
- 6.1.6 жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн хөрөнгө;
- 6.1.7 концессын гэрээ;
- 6.1.8 бусад эх үүсвэр;

Долоо. Зорилтот хөтөлбөрийн үр дүн, шалгуур үзүүлэлт

7.1 Хөтөлбөр хэрэгжсэнээр дараах үр дүнд хүрнэ.

- 7.1.1 эрдэс, түүхий эдийн баталгаат нөөц нэмэгдэж, гангийн үйлдвэр, түүхий эд, материал, хайлшийн үйлдвэрлэлийг урт хугацаанд стандартад нийцсэн түүхий эд, материалаар тогтвортой хангах цогц сүлжээ бүрдсэн байна.
- 7.1.2 гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг хар төмөрлөгийн салбарын тодорхой чиглэл, байршилд зохистой төвлөрүүлэх, эрсдлийг бууруулах нөхцөл бүрдэнэ.
- 7.1.3 олон улсын стандартын шаардлага хангасан ган, хайлш бүтээгдэхүүн, металлургийн кокс үйлдвэрлэгч орон болно.
- 7.1.4 бүтээлч сэтгэхүйтэй инженер, техникийн ажилтан, ажилчдын ажлын бүтээмж өсөж, оюуны өмчийн үнэлгээний орлого нэмэгдэнэ.
- 7.1.5 салбарын ажиллагсад эрүүл мэнд, хариуцлагын эрсдэлээс арилжааны даатгалаар урт хугацаанд хамгаалагдан, мэргэжлээс шалтгаалах өвчөөс урьдчилан сэргийлэгдэж, ирээдүйд ажиллагсдын тэтгэврийн орлого нэмэгдэнэ.
- 7.1.6 2025 оноос төмөр, ган, хайлш бүтээгдэхүүний жилийн экспортын орлого 500 сая ам доллар, 2030 оноос металлургийн коксын экспортын орлого 350 сая ам долларт хүрч хөтөлбөрийн зорилго биелэгдэнэ.

Найм. Зорилтот хөтөлбөрийн хяналт, шинжилгээ, үнэлгээ

8.1. Зорилтот хөтөлбөрийн хэрэгжилтэд аж үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хяналт шинжилгээ хийж, үр дүнг жил бүрийн хоёрдугаар улиралд багтаан Засгийн газарт танилцуулж, олон нийтэд ил, тод мэдээлнэ.

--- оОо ---